



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/712.

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй 91,049,809.98 (ерэн нэгэн сая дөчин есөн мянга найман зуун есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 65,166,149.77 (жаран таван сая нэг зуун жаран зургаан мянга нэг зуун дөчин есөн төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан 3 барилга, Чингэлтэй дүүргийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй 64,498,375.0 (жаран дөрвөн сая дөрвөн зуун ерэн найман мянга гурван зуун далан тав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 57,275,149.09 (тавин долоон сая хоёр зуун далан таван мянга нэг зуун дөчин есөн төгрөг есөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг тус тус акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг эзэмшигч байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

2. Акталж, данснаас хасагдаж байгаа барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой материалыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Л.Хосбаярт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110203340

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 06 дугаар сарын 19-ны өдрийн
 АТ.112 дугаар захирамжийн
 хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

(төгрөг)

Д/д	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Эзэмшигч байгууллага
1	Ус дулаан дамжуулах төв-80	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	69,460,294.57	18,279,024.60	51,181,269.97	НМХГ-ын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-92/71	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Конторын өргөтгөл	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	18	19,363,680.00	5,378,800.20	13,984,879.80		
3	Цехийн барилга	Баянгол дүүрэг, 7 дугаар хороо	19	2,225,835.41	2,225,835.41	0.00	ХСХГ-ын Улсын байцаагчийн 2023 оны 02-13-01/026/211	
Дүн				91,049,809.98	25,883,660.21	65,166,149.77		
4	Салбар байр 4	Чингэлтэй дүүрэг, 23 дугаар хороо	14	61,287,975.00	7,223,225.91	54,064,749.09	НИТХ-ын 2023 оны 122 дугаар тогтоол	Чингэлтэй дүүргийн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" УТҮГ
5	Хашаа	Чингэлтэй дүүрэг, 23 дугаар хороо	12	3,210,400.00	-	3,210,400.00		
Дүн				64,498,375.00	7,223,225.91	57,275,149.09		
Нийт дүн				155,548,184.98	33,106,886.12	122,441,298.86		